



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/48/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261885 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Ч.Дашдаваа  
Утас: 261628 Цахим хаяг: [dashdavaach@audit.gov.mn](mailto:dashdavaach@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Хурц тооцоолол аудит” ХХК  
Захирал: Д.Лхамсүрэн  
Утас: 99980079 Цахим хаяг: [lhama.dorj@gmail.com](mailto:lhama.dorj@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/296  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>123,022,641.03</b>	<b>198,825,439.82</b>
	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>116,994,458.03</b>	<b>190,975,635.82</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	1,139,897.00	368,000.01
33300	Татаас, санхүүжилтийн авлага	115,854,561.03	190,607,635.81
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6,028,183.00</b>	<b>7,849,804.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>4,182,200.00</b>	<b>2,424,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	4,182,200.00	2,424,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,845,983.00</b>	<b>5,425,804.00</b>
35410	Бичиг хэргийн материал	930,639.00	2,911,800.00
35420	Аж ахуйн материал	235,144.00	1,210,104.00
35430	Сэлбэг хэрэгсэл	138,600.00	
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	820,000.00
35470	Бусад хангамжийн материал	41,600.00	483,900.00
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,526,111,528.47</b>	<b>2,872,463,871.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,526,111,528.47</b>	<b>2872,463,871.82</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,969,334,448.33</b>	<b>2,315,839,291.81</b>
39201	Барилга, байгууламж	1,856,422,808.30	1856,422,808.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(169,593,857.20)	(237,807,971.86)
39203	Авто тээврийн хэрэгсэл	75,950,000.00	120,940,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,472,500.00)	(45,933,916.73)
39205	Машин, тоног төхөөрөмж	663,439,124.63	567,110,608.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(488,041,436.87)	(120,391,452.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	209,987,219.35	182,110,092.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(178,754,482.49)	(52,373,119.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	48,586,060.00	10,637,280.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(47,714,419.96)	(3,226,969.70)
39216	Дуусаагүй барилга байгууламж	3,600,000.00	3,600,000.00
39217	Номын Фонд	33,925,932.57	34,751,932.57
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>556,777,080.14</b>	<b>556,624,580.01</b>
39301	Програм хангамж	1,984,000.00	1,474,666.67
39302	Хасагдуулга	(1,302,999.86)	(946,166.66)
39303+393	Бусад биет бус хөрөнгө	556,096,080.00	556,096,080.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,649,134,169.50</b>	<b>3,071,289,311.64</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>0.00</b>
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>0.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>0.00</b>
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг		0.00

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,649,134,169.50</b>	<b>3,071,289,311.64</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,649,134,169.50	3,071,289,311.64
	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,741,521,060.73	1,741,521,060.73
51101	Өмч: Төрийн өмч	1,741,521,060.73	1,741,521,060.73
	Хуримтлагдсан үр дүн	(906,301,859.11)	(484,146,716.97)
51210	Өмнөх үеийн үр дүн	(906,301,859.11)	(906,301,859.11)
51220	Тайлант үеийн үр дүн		422,155,142.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,813,914,967.88	1,813,914,967.88
	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,649,134,169.50</b>	<b>3,071,289,311.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,331,708,231.12</b>	<b>4,810,256,459.81</b>
	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,848,770.00</b>	<b>412,198,780.81</b>
	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>49,848,770.00</b>	<b>412,198,780.81</b>
	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,957,200.00	10,970,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,852,200.00	10,970,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	13,891,570.00	401,228,780.81
	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,281,859,461.12</b>	<b>4,398,057,679.00</b>
	Улсын төвлөрсөн төсвөөс	<b>2,503,385,500.00</b>	<b>2,782,213,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	<b>2,503,385,500.00</b>	<b>2,782,213,100.00</b>
	Нэмэлт санхүүжилтийн орлого	<b>778,473,961.12</b>	<b>1,615,844,579.00</b>
ДТ(131101)	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	<b>141,734,561.12</b>	<b>1,170,980,676.00</b>
ДТ(131104)	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны тасвийн захи	141,082,500.00	153,585,000.00
ДТ(131105)	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	495,656,900.00	291,278,903.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН(II)</b>	<b>3,295,042,878.58</b>	<b>4,353,305,883.34</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,295,042,878.58</b>	<b>4,353,305,883.34</b>
	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,210,944,627.97</b>	<b>4,182,303,038.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,127,548,848.00</b>	<b>2,227,667,382.54</b>
210101+*	Цалин	1,803,069,353.00	1,957,315,384.01
210102+*	Нэмэгдэл цалин	155,684,495.00	116,669,301.26
210103+*	Унаа хоолны хөнгөлөлт	168,795,000.00	153,682,697.27
	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>269,545,401.39</b>	<b>290,994,644.70</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	185,645,042.00	204,036,918.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	21,864,767.00	22,753,535.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	17,038,210.00	17,977,706.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,027,755.39	3,827,748.70
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	39,969,627.00	42,398,737.00
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,068,016.00	54,990,776.88
210301	Гэрэл, цахилгааны зардал	20,457,431.00	19,370,278.88
210302	Түлш, халаалтын зардал	26,136,245.00	29,418,335.00
210303	Цэвэр, бохир усны зардал	3,474,340.00	6,202,163.00
	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>59,032,756.00</b>	<b>179,807,286.47</b>
210401+*	Бичиг хэргийн материал	21,568,172.00	42,398,859.00
210402+*	Тээвэр, шатахууны зардал	4,691,900.00	3,610,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,188,874.00	2,039,364.47
210404	Ном, хэвлэлийн зардал	223,200.00	13,132,600.00
210405+*	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,292,000.00	1,160,000.00
210406+*	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	20,361,310.00	115,241,377.00

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХТ(210407)	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,707,300.00	2,225,086.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	59,517,225.00	74,297,101.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,400,000.00	
210604	Урсгал засвар	54,117,225.00	74,297,101.00
	Томилолт, зочны зардал	5,425,750.00	22,304,270.00
210702	Дотоод томилолтын зардал	5,425,750.00	22,304,270.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,273,499.00	1,175,364,378.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	385,063,979.00	1,171,530,494.93
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,300,000.00	
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	326,700.00	326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	407,480.00	371,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	50,000.00
210807	Газрын төлбөр	5,076,340.00	3,085,684.00
210103	Бараа үйлчилгээний бусад зардал	246,533,132.58	156,877,198.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,511,168.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	480,000.00	7,445,095.00
КТ(210903)	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,541,964.58	149,432,103.13
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>84,098,250.61</b>	<b>171,002,844.69</b>
	Бусад урсгал шилжүүлэг	7,328,000.00	6,590,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,328,000.00	6,590,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,770,250.61	164,412,844.69
КТ(213303)+213	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,770,250.61	164,412,844.69
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>36,665,352.54</b>	<b>456,950,576.47</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>24,852,200.00</b>	<b>34,795,434.33</b>
КТ(225001)	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		34,795,434.33
КТ(225005)	Үнэ төлбөргүй гарсан зардал	24,852,200.00	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV)-(V)</b>	<b>(24,852,200.00)</b>	<b>(34,795,434.33)</b>
	<b>НИЙТ ҮР ДҮН (VII)=(III)+(VI)</b>	<b>11,813,152.54</b>	<b>422,155,142.14</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,741,521,060.73</b>	<b>1,813,914,967.88</b>	<b>(918,115,011.65)</b>	<b>2,637,321,016.96</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,741,521,060.73</b>	<b>1,813,914,967.88</b>	<b>(918,115,011.65)</b>	<b>2,637,321,016.96</b>
4	Дахин үнэлгээний нэмэгдэл,хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	11,813,152.54	11,813,152.54
<b>8</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,741,521,060.73</b>	<b>1,813,914,967.88</b>	<b>(906,301,859.11)</b>	<b>2,649,134,169.50</b>
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,741,521,060.73</b>	<b>1,813,914,967.88</b>	<b>(906,301,859.11)</b>	<b>2,649,134,169.50</b>
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	422,155,142.14	422,155,142.14
<b>16</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,741,521,060.73</b>	<b>1,813,914,967.88</b>	<b>(484,146,716.97)</b>	<b>3,071,289,311.64</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,662,886,993.91</b>	<b>4,513,912,240.03</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,662,886,993.91</b>	<b>4,513,912,240.03</b>
	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,263,741,400.00</b>	<b>2,782,213,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,263,741,400.00	2,782,213,100.00
	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>399,145,593.91</b>	<b>1,731,699,140.03</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	76,919,700.00	1,266,559,237.03
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	122,198,500.00	153,585,000.00
131105	Төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,027,393.91	311,554,903.00
	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,390,523,046.00</b>	<b>4,384,561,140.03</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,390,523,046.00</b>	<b>4,384,561,140.03</b>
	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,390,523,046.00</b>	<b>4,022,950,659.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>947,902,493.00</b>	<b>2,091,499,536.86</b>
210101	Үндсэн цалин	741,205,927.00	1,622,722,975.86
210102	Нэмэгдэл	133,234,566.00	274,367,561.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,462,000.00	194,409,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>122,220,586.00</b>	<b>273,167,111.58</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	84,301,455.00	194,568,530.08
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,585,692.00	20,648,041.89
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,666,043.00	16,155,554.38
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,818,532.00	3,758,904.85
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	16,848,864.00	38,036,080.38
	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,942,301.00</b>	<b>53,612,000.96</b>
210301	Гэрэл, цахилгааны зардал	10,818,036.00	19,370,278.88
210302	Түлш, халаалтын зардал	18,375,752.00	29,418,335.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,748,513.00	4,823,387.08
<b>220103</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,922,765.00</b>	<b>40,299,590.32</b>
210401	Бичиг хэрэг	1,911,020.00	7,113,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,116,000.00	1,510,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,119,153.00	2,224,074.47
210404+*	Ном, хэвлэл	552,200.00	22,546,028.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	1,160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,359,392.00	5,729,937.00
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,330,000.00</b>	<b>114,680,511.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	330,000.00	49,180,511.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		4,500,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	61,000,000.00
	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,334,450.00</b>	<b>20,158,520.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,334,450.00	20,158,520.00
	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>134,958,593.00</b>	<b>1,422,088,293.81</b>

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	131,869,613.00	1,415,754,409.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,300,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		326,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,980.00	371,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	50,000.00
210807	Газрын төлбөр	290,000.00	3,085,684.00
	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,911,858.00</b>	<b>7,445,095.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,431,858.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	7,445,095.00
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>361,610,480.50</b>
	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>6,590,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,590,000.00
	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>355,020,480.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		164,412,844.69
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг / Нэмэлт санхүүжилт/		190,607,635.81
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>272,363,947.91</b>	<b>129,351,100.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>34,128,000.00</b>	<b>129,351,100.00</b>
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,128,000.00</b>	<b>129,351,100.00</b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>34,128,000.00</b>	<b>129,351,100.00</b>
2	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<b>34,128,000.00</b>	<b>129,351,100.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(34,128,000.00)</b>	<b>(129,351,100.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>238,235,947.91</b>	<b>0.00</b>
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
ЭЦ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	238,235,947.91	

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,782,213,100.00</b>	<b>2,617,800,255.31</b>	<b>164,412,844.69</b>	94.1
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,782,213,100.00</b>	<b>2,617,800,255.31</b>	<b>164,412,844.69</b>	94.1
Бараа, үйлчилгээний зардал	2,775,621,900.00	2,611,210,255.31	164,411,644.69	94.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,159,550,000.00	2,026,433,501.86	133,116,498.14	93.8
Үндсэн цалин	1,595,887,600.00	1,557,656,940.86	38,230,659.14	97.6
Нэмэгдэл	329,230,400.00	274,367,561.00	54,862,893.00	83.3
Унаа болон бусад нөхөн олговор	234,432,000.00	194,409,000.00	40,023,000.00	82.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>291,539,300.00</b>	<b>264,326,647.02</b>	<b>27,212,652.98</b>	90.7
Тэтгэврийн даатгал	205,157,300.00	185,728,065.52	19,492,234.48	90.5
Тэтгэмжийн даатгал	21,595,500.00	20,648,041.89	947,458.11	95.6
ҮОМШӨ-ний даатгал	17,276,400.00	16,155,554.38	1,120,845.62	93.5
Ажилгүйдлийн даатгал	4,319,100.00	3,758,904.85	560,195.15	87.0
Эрүүл мэндийн даатгал	43,191,000.00	38,036,080.38	5,154,919.62	88.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53,612,400.00</b>	<b>53,612,000.96</b>	<b>399.04</b>	100.0
Гэрэл, цахилгаан	24,088,600.00	19,370,278.88	4,718,321.12	80.4
Түлш, халаалт	26,435,000.00	29,418,335.00	(2,983,335.00)	111.3
Цэвэр, бохир ус	3,088,800.00	4,823,387.08	(1,734,587.08)	156.2
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,550,400.00</b>	<b>17,549,971.47</b>	<b>428.53</b>	100.0
Бичиг хэрэг	2,410,800.00	5,198,550.00	(2,787,750.00)	215.6
Тээвэр, шатахуун	1,565,400.00	1,510,000.00	55,400.00	96.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,020,600.00	2,240,074.47	(219,474.47)	110.9
Ном, хэвлэл	1,984,000.00	1,711,410.00	272,590.00	86.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,113,600.00	1,160,000.00	(46,400.00)	104.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	8,456,000.00	5,729,937.00	2,726,063.00	67.8
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>160,000,000.00</b>	<b>156,809,511.00</b>	<b>3,190,489.00</b>	98.0
Багаж, техник, хэрэгсэл	94,500,000.00	91,309,511.00	3,190,489.00	96.6
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00		100.0
Урсгал засвар	61,000,000.00	61,000,000.00		100.0
Томилолт, зочны зардал	8,400,000.00	8,400,000.00		100.0
Дотоод албан томилолт	8,400,000.00	8,400,000.00		100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>77,377,800.00</b>	<b>76,633,528.00</b>	<b>744,272.00</b>	99.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,766,600.00	70,299,644.00	466,956.00	99.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал	2,500,000.00	2,500,000.00		100.0
Даатгалын үйлчилгээ	326,700.00	326,700.00		100.0
Тээврийн хэрэгслийн татвар	467,500.00	371,500.00	96,000.00	79.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	165,000.00	50,000.00	115,000.00	30.3
Газрын төлбөр	3,152,000.00	3,085,684.00	66,316.00	97.9

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,592,000.00</b>	<b>7,445,095.00</b>	146,905.00	98.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,592,000.00	7,445,095.00	146,905.00	98.1
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,591,200.00</b>	<b>6,590,000.00</b>	<b>1,200.00</b>	<b>100.0</b>
Бусад урсгал шилжүүлэг	6,591,200.00	6,590,000.00	1,200.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,591,200.00	6,590,000.00	1,200.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,782,213,100.00</b>	<b>2,617,800,255.31</b>	164,412,844.69	94.1
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,782,213,100.00</b>	<b>2,617,800,255.31</b>	164,412,844.69	94.1
Улсын төсвөөс санхүүжих	2,782,213,100.00	2,617,800,255.31	164,412,844.69	94.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>158.00</b>	<b>158.00</b>		
Удирдах ажилтан	1.00	1.00		
Гүйцэтгэх ажилтан	133.00	133.00		
Үйлчлэх ажилтан	24.00	24.00		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>1,731,699,140.03</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,731,699,140.03</b>
Бараа, үйлчилгээний зардал		1,541,091,504.22
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>65,066,035.00</b>
Үндсэн цалин		65,066,035.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>8,840,464.56</b>
Тэтгэврийн даатгал		8,840,464.56
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>23,575,618.85</b>
Бичиг хэрэг		1,915,000.00
Ном, хэвлэл		21,660,618.85
<b>Эд хогшил худалдан авах</b>		<b>7,050,000.00</b>
Багаж техник хэрэгсэл		7,050,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>11,758,520.00</b>
Дотоод албан томилолт		11,758,520.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>		<b>1,424,800,865.81</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		1,424,800,865.81
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>190,607,635.81</b>
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>190,607,635.81</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг		190,607,635.81
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>1,731,699,140.03</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>1,731,699,140.03</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,266,559,237.03
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		153,585,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		311,554,903.00
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>158.00</b>	<b>158.00</b>
Удирдах ажилтан	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	133.00	133.00
Үйлчлэх ажилтан	24.00	24.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хэрэгжилт, бодлогын баримт бичгийн боловсруулалт, тооллого, тайлант хугацаанд хийсэн худалдан авалтуудтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Хурц тооцоолол аудит” ХХК-ийн ахлах аудитор Э.Учралзаяа, аудиторын туслах О.Мөнхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын менежер Д.Наранчимэг хэрэгжүүлсэн.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Хурц тооцоолол аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Газарзүй, Геоэкологийн хүрээлэн нь Газар зүй, хөрс, ус, агаар, газар, ой, цөлжилт, цэвдэг судлал, газарзүйн мэдээллийн систем, зурагзүйн чиглэлээр онолын болон хэрэглээний судалгаа хийх, нийгмийн эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, санал дэвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,281,59.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 65,900.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 422,155.1 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Авлага	116,994.5	190,975.6	73,981.1
Бараа материал	6,028.2	7,849.8	1,821.6
Үндсэн хөрөнгө	2,526,111.5	2,872,463.9	346,352.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,649,134.2</b>	<b>3,071,289.3</b>	<b>422,155.1</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,649,134.2	3,071,289.3	422,155.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,649,134.2</b>	<b>3,071,289.3</b>	<b>422,155.1</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага дансны үлдэгдэл 190,975.6 мянган төгрөг болж, 73,981.1 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой хээрийн судалгааны зардал, зарим гэрээт ажлууд хийгдэж амжаагүйгээс шалтгаалжээ. Одоогоор он удаан жил үүссэн авлага байхгүй байна.
- ✓ Бараа материалын дансны үлдэгдэл 7,849.8 мянган төгрөг болж, 1,821.6 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 08-ны 365 тоот тогтоолоор Үндсэн хөрөнгөөс бараа материал руу сансраас мэдээлэл авдаг тоон мэдээллүүд шилжсэнтэй холбоотой байна.



- ✓ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,872,463.9 мянган төгрөг болж, 346,352.4 мянган төгрөгөөр өссөн нь 2021 онд төсвийн хөрөнгөөр авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,782,213.1 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 2,617,800.2 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 164,412.8 мянган төгрөгөөр бууруулан 2,617,800.2 мянган төгрөгөөр баталсан, 2021 оны төсөв 2,773,200.0 мянган төгрөгөөр батлагдсан боловч Сангийн яамны тодотголоор 2,743,700.0 мянган төгрөг болон нийт 29,500.0 мянган төгрөгөөр бууруулж төсөвт тодотгол хийсэн.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан технологи хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,782,213.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,617,800.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,782,213.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,617,800.2 мянган төгрөгийг зарцуулж, 164,412.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	2,782,213.1	2,617,800.2	164,412.8	94.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,734,513.1	2,570,567.2	163,945.9	94.0
1.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	47,700.0	47,233.0	466.9	99.0

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ, Шинжлэх ухаан технологийн хөтөлбөрийн харуул хамгаалалтын арга хэмжээ 164,412.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 65,066.0 мянган төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8,840.5 мянган төгрөг, Хангамж, бараа материалын зардалд 23,575.6 мянган төгрөг, Эд хогшид худалдан авахад 7,050.0 мянган төгрөг, Дотоод томилолтын зардалд 11,758.5 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлэх, төлбөр хураамжийн зардалд 1,424,800.5 мянган төгрөг, нийт 1,731,699.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 190,607.6 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 94.1 хувийн биелэлттэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
24.5	Код	Нэр				
1	24.5.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	38.3	38.3	-	100.0
2	24.5.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	85	85	-	100.0
3	24.5.3	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	75	75	-	100.0
Дундаж хувь						100.0

### 3.8 Аудитын гол асуудал

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны системд оруулах ёстой 173 мэдээллээс байршуулсан 169 мэдээ үүнээс хугацаа хоцорсон 4, хугацаандаа 169 мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн тайлант онд нийт 1,853,291.8 мянган төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 112,920.3 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөвлөмж өгөх.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 2,312.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 алдаа зөрчилд 2,312.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 27,549.6 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийн хэрэгжилт 85.7 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	7	27,549.6	6	27,549.6	-	-	85.7
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>27,549.6</b>	<b>6</b>	<b>27,549.6</b>	-	-	<b>85.7</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэм шинжилгээний төслүүдийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийж, гэрээт ажил гүйцэтгэж байгаа ажил нь бүртгэлээр шууд хяналт тавих боломжгүй тул дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,022.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2 алдаа зөрчлийг залруулж, 5,022.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн дүн 5,022.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 52,720.6 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол, тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын илтгэх хуудасгүй, тооллогын тооцоог нэгтгэн баримтжуулаагүй.
- Шилэн дансны 4 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5,022.0 мянган төгрөгийн и төлбөрийн баримтгүй, ажил гүйлгээ хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн болон татварын тухай хуулийг хэрэгжүүлж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, тайланг үнэн зөв бэлтгэх

**2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй, хуулийн өөрчлөлт хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль эрх зүйн актын дагуу шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр нь оруулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Газарзүй геоэкологийн хүрээлэн	АХГ-2022/48/Н А-СТА-ТШЗ	2021 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын илтгэх хуудасгүй, тооллогын тооцоог нэгтгэн баримтжуулаагүй.	Зөвлөмж	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
2	Газарзүй геоэкологийн хүрээлэн	АХГ-2022/48/Н А-СТА-ТШЗ	И төлбөрийн баримтгүй худалдан авалтууд байна.	Зөвлөмж	1	5,022.0	-	-	-	-	-	-	-	-	1	5,022.0
3	Газарзүй геоэкологийн хүрээлэн	АХГ-2022/48/Н А-СТА-ТШЗ	НББ-ийн бодлогын баримт бичгийг хууль, эрх зүйн актын дагуу шинэчлэн, мөрдөж ажиллаагүй.	Зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>					<b>3</b>	<b>5,022.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>5,022.0</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Газарзүй геоэкологийн хүрээлэн	АХГ-2022/48/Н А-СТА-ТШЗ	Шилэн дансны системд оруулах ёстой 173 мэдээллээс байршуулсан 169 мэдээ үүнээс 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	Зөвлөмж	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Нийцлийн аудитын Дүн					<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Нийт дүн					<b>4</b>	<b>5,022.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>5,022.0</b>